



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2014 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 01/209

Арвайхээр

Журам батлах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "г", Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйл, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2014 оны 204 дүгээр захирамжаар батлагдсан "Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Аймгийн Засаг даргын нөөц сангаас нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлэх журам"-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Дээрх журмын хэрэгжилтэнд хяналт тавьж, танилцуулга бэлтгэн хагас, бүтэн жилээр аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, иргэдэд мэдээлж байхыг Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга /Н.Энхцэцэг/-т үүрэг болгосугай.

3.Энэхүү журам батлагдсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2012 оны а/262 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ТОГТОХСҮРЭН

02 050⁰

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2014 оны ...
дугаар сарын ... ны өдрийн ... дугаар
захирамжийн хавсрагт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НӨӨЦ САНГААС НЭГ УДААГИЙН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоолыг удирдлага болгоно.

1.2. Иргэдээс аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт хандан нэг удаагийн буцалтгүй тусламж олгохыг хүсч ирүүлсэн өргөдлийг хүлээн авч шийдвэрлэхэд энэхүү журмыг баримтлана. Иргэдэд олгох нэг удаагийн буцалтгүй тусламж олгох зардлыг аймгийн Засаг даргын нөөц сангаас санхүүжүүлнэ.

ХОЁР. БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ ОЛГОХ НӨХЦӨЛ

2.1. Өрхийн орлогогүй, нэн ядуу өрхийн гишүүнд;

2.2. Төрийн байгууллага, аж ахуйн нэгжид олон жил ажиллаж байгаа болон ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан /Хөдөлмөрийн баатар, гавъяат, алдар цолтон/ иргэний ахуй амьдрал нь гачигдалтай байгаа тохиолдолд;

2.3. Гэр оронгүй, тэжээн тэтгэх хүүхэд, төрөл садангүй, бие даан амьдрах чадваргүй /хүнд өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй/ иргэнд;

2.4. Байгалийн гэнэтийн гамшиг, осолд өртөж нэрвэгдсэн иргэнд;

ГУРАВ. ӨРГӨДЛИЙГ ХҮЛЭЭН АВАХ, ХЭЛЭЛЦЭН ШИЙДВЭРЛЭХ

3.1. Иргэний тусламж хүссэн өргөдлийг аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн архив, бичиг хэргийн эрхлэгч хүлээн авч хяналтын карт нээж, аймгийн Засаг даргад /түүний эзгүйд Засаг даргын орлогч, Засаг даргын Тамгын газрын дарга/-д танилцуулна.

3.2. Эрх бүхий албан тушаалтан энэхүү журмын нөхцөлд хамаарах иргэний өргөдлийг аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн холбогдох ажилтанд удирдлагын заалтаар үүрэг өгнө.

3.3. Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн өргөдөл, гомдлын асуудал хариуцсан ажилтан өргөдөлтэй танилцан харъяа сумын ЗДТГ, багийн Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтнаас тухайн иргэний талаар нэмэлт мэдээлэл, судалгааг шаардлагатай тохиолдолд авч энэхүү журмыг үндэслэн буцалтгүй мөнгөн тусламж

үзүүлэх талаарх саналаа ажлын хэсэгт танилцуулж, аймгийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэнэ.

3.4. Албан тушаалтан иргэдийн өргөдлийг хуулийн хугацаанд буюу 30 хоногийн дотор шийдвэрлэж, хариуг эзэнд нь амаар болон албан бичгээр хүргүүлнэ.

3.5. Байгалийн гамшиг, гэнэтийн осолд өртсөн, журмын 2.2-т заасан гачигдалтай иргэнд олгох тусламжийг өргөдөлгүйгээр аймгийн Засаг дарга тухайн үеийн хойшлуулшгүй нөхцөл байдлыг нь харгалзан үзэж, тусламж үзүүлэх асуудлыг шууд шийдвэрлэж болно.

3.6. Иргэнд нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлэх тухай аймгийн Засаг даргын захирамжийн 1 хувийг аймгийн ЗДТГ-ын санхүүд хүргүүлнэ. Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн өргөдөл, гомдлын асуудал хариуцсан ажилтан аймгийн Засаг даргаас олгосон буцалтгүй тусламжид хамрагдсан иргэдийн судалгааг тухайн жилээр нэгтгэн аймгийн Засаг даргад мөн оны 12 дугаар сарын 15-ны дотор танилцуулж байна.

3.7. Буцалтгүй тусламжийг олгохдоо иргэний үнэмлэх болон бусад бичиг баримтыг үндэслэн аймгийн ЗДТГ-ын нярав гарын үсэг зуруулж баталгаажуулна. Нэг удаагийн тусламжийг иргэнд олгохдоо аймгийн Засаг дарга, түүний эзгүйд аймгийн ЗДТГ-ын дарга биечлэн олгоно. Хүндэтгэн үзэх шалтгаантай иргэнд буцалтгүй тусламжийг эрх бүхий албан тушаалтан болон өргөдөл, гомдлын асуудал хариуцсан ажилтан биеэр хүргэж өгч болно.

3.8. Буцалтгүй тусламж хүссэн иргэн өргөдөл шийдвэрлэлтийн явцад нас барсан тохиолдолд түүний гэр бүлийн гишүүнд нь олгоно. Арвайхээр сумаас бусад сумын иргэнд олгохоор шийдвэрлэсэн буцалтгүй тусламжийг шийдвэрийн хамт тухайн сумын Засаг даргаар дамжуулан олгож болно.

3.9. Аймгийн Засаг дарга, Тамгын газраас журмын дагуу буцалтгүй тусламж үзүүлэх боломжгүй буюу энэхүү журамд заагдаагүй нөхцөлтэй тохиолдолд өргөдлийг хуулбарлан, холбогдох төрийн байгууллага, албан тушаалтанд шилжүүлнэ.

3.10. Аймгийн Засаг даргаас олгох буцалтгүй тусламжийг нэг иргэнд 2 жилийн дотор давхардуулан олгохгүй.

ДӨРӨВ. БУЦАЛТГҮЙ МӨНГӨН ТУСЛАМЖИЙН ТӨРӨЛ, ХЭМЖЭЭ

4.1. Иргэнд олгох нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламжийн хэмжээ нь энэхүү журмын

- 2.1-д заасан нөхцөлд 50.0 мянган төгрөг хүртэл,
- 2.2, 2.3-д заасан нөхцөлд 200.0 мянган төгрөг хүртэл,
- 2.4-д заасан нөхцөлд 300.0 мянган төгрөг хүртэл байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР